БАТЛАВ:
"ЭРДЭНЭТ УС, ДТС" ОНӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.БҮҮВЭЙБААТАР

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ
ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ № 24/115

2024 оны ... дугаар сарын ... Эрдэнэт хот

1. Хэрэглэгчийн нэр, хаяг..... *2х1000кВА чадалтай ТП маягийн дэд өртөө*
2. Хүсэлт гаргасан иргэн, ААНБ..... *Хотын захирагчийн алба*
3. Хэрэглэгчийн байршил..... *Оюут баг, 2А-р хороолол*
4. Ажил үйлчилгээний зориулалт..... *Хуваарилах байгууламж*
5. Техникийн нөхцөл олгох үндэслэл:..... *Хотын захирагчийн албаны албан бичиг*
6. Хүчдэлийн түвшин:..... *6/0.4кВ-ын 2х1000кВА чадалтай ТП маягийн дэд өртөө*
7. Тоолуур:..... *Ачаалалдаа тохирсон стандартын ухаалаг тоолуур.*
8. Хүчдэлийн кабелийн марк..... *10кВ-ын АБЛу-3х240мм² хөндлөн огтлолтой кабель шугам.*
9. Холбогдох цэг:..... *6/0.4 кВ ТП-526 дэд өртөө*
10. Тусгай заалтууд:.....

- *6/0.4 кВ ТП-526 дэд өртөөний РУ-6кВ-ын ячейка-7,8-д шинээр КСО суурилуулан шинээр баригдах 6/0.4кВ-ын 2х1000кВА чадалтай дэд өртөөний РУ-6кВ-д холбох.*
- *6кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам нь ОХУ-д үйлдвэрлэгдсэн АБЛу-3х240 марктай байна. Тэжээлийн кабель ямар нэг залгаасгүй байх.*
- *Шинээр баригдах дэд өртөө нь 6кВ-ын секц тус бүрдээ хамгийн цөөндөө гаргалгааны 3, трансформаторын 1 ячейкатай байна. 6кВ-ын ячейканы өргөн нь 0,8м-ээс ихгүй байх ёстой.*
- *2х1000кВА трансформаторын дэд өртөөний транформаторын өрөөний хэмжээ, 0.4кВ-ийн оролтын ячейка, 0.4кВ-ийн секц холбогч ячейкийн тоноглолуудыг сонгохдоо ойрын ирээдүйд 1600кВА трансформатороор тоноглогдохоор тооцож сонгоно.*
- *6кВ-ын трансформаторын дэд өртөөний ханын материал нь шатдаггүй хатуу (ханан дээр хийц эдлэхүүн тогтоож болохуйц) материалтай байна*
- *Трансформаторын дэд өртөөний барилга нь гадна талаасаа орчныхоо архитектурт уусч нийцсэн өнгө, үзэмж, засал, хийцтэй байх. Дээврийн ус хаалгатай хана тал руу урсахааргүй байх.*
- *Өндөр талдаа трансформаторын дэд өртөөний барилга нь секц тус бүрдээ 1,1 ячейка нэмэх зайтай байх.*
- *Трансформаторын дэд өртөөний барилга нь нам талын секц тус бүрдээ 4, 4 гаргалга нэмэх зайтай байх.*

- *Нэг маягын трансформаторын дэд өртөөний 0,4 кВ-ийн ХБ-ын секц тус бүрд 12-оос доошгүй групп тоноглогдсон байна.*
- *Цуглуулгын шин болон түүнээс салбарласан шинүүд нь өнгө ялгасан тэмдэглэгээтэй байна.*

  -А фазыг шар

  -В фазыг ногоон

  -С фазыг улаан

  Фазын өнгийн тэмдэглэгээг шинийг будах байдлаар хийхийг хориглоно. Шин дээр халууны аргаар агшиж сунадаг тусгай зориулалтын өнгийн бүрээсээр дээрх тэмдэглэгээг хийсэн байна. Ажлын газардуулгыг хар өнгөөр тэмдэглэх ба газардуулагч утаснууд ногоон эсвэл шар өнгийн тэмдэглэгээтэй байна.
- *Ажлын зураг төсөл зөвшилцөх шатанд суурилуулах тоног төхөөрөмжийн марк, схемийг ЭУДТС ОНӨХК-иар хянуулсан байх.*
- *Шинээр баригдах дэд станц нь орчин үеийн шинэ тоног төхөөрөмжөөр тоноглогдсон иж бүрдэл байна.*
- *Цахилгааны ачааллыг 30 хүртэлх хувиар нэмэх, барилгын өргөтгөл хийх тохиолдолд техникийн нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулан, техникийн нөхцөлийг шинээр авах.*
- *Кабелийн сувгийг 60-80 см ухаж кабелийн хамгаалалт элс, тоосго хийсэн байх.*
- *Шинээр баригдах дэд станц болон барилгын гадна инженерийн шугам сүлжээ, дотор инженерийн шугам сүлжээний ажлын болон гүйцэтгэлийн зургийг хангагч байгууллагад хүвилж өгөх.*
- *Техникийн нөхцөлийн дагуу холболт хийсний дараа эдийн засагчтай гэрээ хийх.*
- *Техникийн нөхцөлд заагдаагүй ашиглалтын шаардлага хангахгүй цахилгаан тоноглол хэрэглэснээс гарсан гэмтэл саатал хохирлыг техникийн нөхцөл олгосон байгууллага хариуцахгүй.*
- *Техникийн нөхцөлд заагдсан арга хэмжээг дутуу авсан тохиолдолд ЦЭХ-ээр хангахгүй болно.*

11. Дор дурдсан техникийн даалгавар, хууль, дүрмийг мөрдөх.

- *Шугамын трассын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэж, ГХБХБГ-ын инженер болон компанийн өрөнхий инженерээр батлуулах.*
- *Кабель шугамын трасс, хамгаалалтын зурваст барилга барих, зам талбай засах, бетондохыг хориглоно. Шаардлагатай тохиолдолд кабелийг таг бүхий тусгай сувагт байрлуулах.*
- *Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээх зардлыг төсөвт тусгах.*
- *Цахилгаан угсралтын ажлыг мэргэжлийн байгууллагаар аюулгүй ажиллагааны дүрэм, техник ашиглалтын дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.*

  /БНбД 3.05.06-90, БД43-101-03, БД 43-103-08 дүрмийн дагуу хийх/
- *Хүчдэлийн түвшний ±5%-ийн хэлбэлзэлд зохицсон тоноглол суурилуулах.*
- *Засгийн газрын 2001 оны 263 тоот тогтоолоор батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн заалтыг мөрдлөг болгох.*
- *Тооцооны хэрэглэлийг ашиглалтын хил хязгаарын зааг дэд станцад байрлуулах ба ачаалалдаа тохирсон гүйдлийн трансформаторыг баталгаажуулан зориулалтын хайрцагт битүүмжлэн байрлуулна.*

- *Цахилгаан эрчим хүчний тооцоог сар бүрийн 5-ны дотор "Эрдэнэт Ус, ДТС" ОНӨХК-тай хийх.*
- *Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд техникийн нөхцөлийн үйлчлэх хугацаа дуусахаас 2 сарын өмнө техникийн нөхцөл олгогчид хандаж шинээр техникийн нөхцөл авна.*
- *Энэхүү техникийн нөхцөл нь барилгын зураг төсөв хийхэд хүчинтэй.*

ТЕХНИКИЙН КОМИССЫН ГИШҮҮД:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР	Ц.УУГАНБАЯР
ИЭЗБТХ-ИЙН ДАРГА	О.ЭНХ-АРИУН
ЦАХИЛГААНЫ АЛБАНЫ ДАРГА	Д.ДОНГООДАВАА
БОРЛУУЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГА	Г.УРАНЦЭЦЭГ
ИЭЗБТХ-ИЙН ИНЖЕНЕР	Д.БУЛГАНЗАЯА